

2023 он 11 сар 24 өдөр

Дугаар 23/38

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### *Хувьцааны хяналтын багц худалдан авах санал гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 56.1, 56.2, 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1.1, Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журам болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 23-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хамтран хөрөнгө оруулалтын зорилгоор Өндөрхаан ХК (ОНН)-ийн нийт гаргасан энгийн хувьцаанаас 49,900 ширхэг (44.6 хувь) хувьцааг худалдан авах саналыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 сарын 20-ны 38 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-д заасан Өндөрхаан ХК-ийн 49,900 ширхэг хувьцаанаас компани 36,472 ширхэг (32.6 хувь) хувьцааг худалдан авах санал гаргах бөгөөд компанийн нэгдмэл сонирхолтой бусад этгээдүүдийн саналыг нэгтгэн компани эрх бүхий этгээдэд хууль, журмын дагуу мэдээлэхийг дүрдсугай.
3. Сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргахтай холбоотой мэдэгдэлд санал болгож буй үнэ 10,660 төгрөг, худалдан авах саналын эхлэх хугацааг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр, дуусах хугацааг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, хувьцааны худалдан авах төлбөрийн хугацааг 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр тус тус байхаар баталсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох арга хэмжээг авч, зардлыг компаниас гаргахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б. Золбоо)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА Ч.БАНХУЯГ

